

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АХБ	Азийн хөгжлийн банк
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ,
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ
(MON 48076-002, L3605/G9191)”-ИЙН
ЗАХИРАЛ С.ТУНГАЛАГТАМИР ТАНАА

2020.04.16 № 06/1141
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, үнэн, зөв бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал С.Тунгалагтамир Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн нэмэгдсэн өртгийн албан татварын тайлантай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн зохицуулагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 2-ноос 2020 оны 04 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Грант Торнтон аудит” ХХК-ийн аудитор Г.Батхишиг, туслах аудитор Б.Базарсад нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 04 дүгээр сарын 2-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын Засгийн газар нийслэл Улаанбаатар хот, аймгуудын түвшинд ХБИ-дэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм. Төслийн эцсийн зорилго бол ХБИ-ий бие даах чадварыг дээшлүүлж, нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршиж байна.

Төслийн хүрээнд сонгогдсон Архангай, Дархан-Уул, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгуудад болон Улаанбаатар хотод ХБИ-ийн тоо болон ядуурлын түвшин харьцангуй өндөр үзүүлэлттэй байгааг үндэслэн орчин үеийн, үр ашигтай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв” барилга байгууламжийн угсралтын ажил, зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангах ажлуудыг 2018-2022 онуудад барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Азийн хөгжлийн банк нь энэхүү зээлийн гэрээ болон Азийн Хөгжлийн банк ба Монгол улсын хооронд байгуулсан гэрээний дагуу Азийн хөгжлийн банкны энгийн хөрөнгийн нөөцөөс 25,000.0 мянган ам.доллартай тэнцэх зээл олгохыг зөвшөөрч, Азийн Хөгжлийн банкны Захирлуудын зөвлөл 2018 оны 04 дүгээр сарын 4-нд баталсан.

Төсөл нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, Японы ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламж, Монгол улсын Засгийн газрын биет бус туслалцаа буюу дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт зэрэг санхүүжилтийн эх үүсвэрээр 2018 оны 04 дүгээр сарын 30-наас 2022 оны 12 дугаар сарын 30-ны дотор хэрэгжинэ.

Төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэдийн амьдралын мөчлөгт чиглэсэн үйлчилгээ, дэмжлэгийн эрэлт хэрэгцээг хангах зорилго бүхий дараах 5 бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах
3. Орчны хүртээмжийг сайжруулах
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг хэрэгжүүлэх

Тус төслийн нийт өртөг Азийн хөгжлийн банкнаас 25,000.0 мянган ам.доллар, Японы ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламж 2,000.0 мянган ам.доллар, Монгол Улсын Засгийн газраас 270.0 мянган ам.доллар нийт 27,270.0 мянган ам.доллар байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191) ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг (САГ-2020/738/СТА-ТХН)

нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191) нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Infosystems Pacs” программ хангамж ашигладаг байна.

Төслийн удирдах нэгжийн үйл ажиллагааг Сангийн Сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны 196 дугаар тушаалаар батлагдсан Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгийг ашиглах, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмаар зохицуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Нийт зардлаас тооцох шалтгаан нь төсөл гадаадын эх үүсвэрээс санхүүждэг, зардалд суурилдаг учраас нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 836,524.2 мянган төгрөгөөс тооцон 8,365.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд дараах байдалтай байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	277,390.8	1,748,080.1	1,470,689.4
Авлага	6,987.3	-	(6,987.3)
Үндсэн хөрөнгө	70,978.1	199,497.0	128,519.0
Нийт хөрөнгө	355,356.1	1,947,577.2	1,592,221.0
Өр төлбөр	2,145.0	67,810.1	65,665.1
Хуримтлагдсан үр дүн	353,211.1	1,879,767.1	1,526,556.0
Өр төлбөр ба цэвэр өмчийн дүн	355,356.1	1,947,577.2	1,592,221.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь Азийн хөгжлийн банкнаас олгосон санхүүжилтээс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь татаас, санхүүжилтийн авлагаа тайлант онд авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өсөлтөд тайлант онд худалдан авсан 156,230.0 мянган төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж, элэгдлийн дүн 27,711.0 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь нийлүүлэгч байгууллагын өглөг өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний 70 хувь буюу 67,810.1 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийг хэрэгжүүлэхэд зориулан гадаад зээл 1,561,969.6 мянган төгрөг, гадаад тусламж 443,916.5 мянган төгрөг нийт 2,005,886.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Нийт зардлыг Азийн Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Төслийн мөнгөн хөрөнгөнд гүйцэтгэлээр 2,255,475.2 мянган төгрөгийг Азийн хөгжлийн банкнаас авч, 834,614.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын төсвийн орлого хяналтын газар нь төсөлд 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдөр НӨАТ төлөгчийн 9917225 дугаарыг НӨАТ-аас чөлөөлөгдөхгүй худалдан авалтанд олгон, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Гэтэл энэ нь татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шивэгдсэн НӨАТ-аас чөлөөлөгдөхгүй худалдан авалтын И-баримтын

10 хувь системд салж бүртгэгдэхгүй, НӨАТ-тай борлуулалт нь чөлөөлөгдсөнөөр бүртгэгдэж байна. Иймд дараагийн аудитаар НӨАТ-аас чөлөөлөгдөхгүй худалдан авалтын И-баримтын 10 хувь системд салж бүртгэгдсэн эсэхэд анхаарах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON 48076-002, L3605/G9191)-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	284,378,052.82	1,748,080,139.72
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	277,390,760.82	1,748,080,139.72
312	Харилцах дансанд байгаа мөнгө - төгрөг	-	274,390,295.05
3122	Харилцах дансанд байгаа мөнгө - ам доллар	277,390,760.82	1,473,689,844.67
33	АВЛАГА	6,987,292.00	-
33300	Татаас , санхүүжилтийн авлага	6,987,292.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	70,978,066.00	199,497,022.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	70,978,066.00	199,497,022.76
39200	Биет хөрөнгө	63,828,066.00	194,730,356.09
39203	Автотээврийн хэрэгсэл	-	152,730,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(10,182,000.00)
39205	Компьютер, тоног төхөөрөмж	34,976,646.00	38,476,646.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(12,260,567.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,851,420.00	28,851,420.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,885,142.00)
39300	Биет бус хөрөнгө	7,150,000.00	4,766,666.67
39301	Программ хангамж	7,150,000.00	4,766,666.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	355,356,118.82	1,947,577,162.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,145,000.00	67,810,050.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,145,000.00	67,810,050.00
413	Өглөг	2,145,000.00	67,810,050.00
41320	Бараа, үйлчилгээний зардлын өглөг	2,145,000.00	67,810,050.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	353,211,118.82	1,879,767,112.48
512	Хуримтлагдсан үр дүн	353,211,118.82	1,879,767,112.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-	353,211,118.82
51220	Тайлант үеийн үр дүн	353,211,118.82	1,526,555,993.66
6	ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ӨМЧИЙН ДҮН	355,356,118.82	1,947,577,162.48

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	540,532,643.91	2,320,581,038.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	540,532,643.91	2,320,581,038.45
120	Нийтлэг татварын бус орлого	540,532,643.91	1,897,391,884.45
12000	Туслах үйл ажиллагааны орлого	1,485,743.91	23,645,110.87
12000	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	539,046,900.00	1,832,286,115.98
120009	Бусад орлого	-	41,460,657.60
1220	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	-	423,189,154.00
122002	Буцалтгүй Тусламжийн орлого	-	423,189,154.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	201,550,612.90	430,300,427.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	201,550,612.90	430,300,427.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,550,612.90	406,997,316.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	59,092,800.00	232,523,014.61
210101	Цалин	59,092,800.00	232,523,014.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,091,136.00	29,065,377.75
210201	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	7,091,136.00	29,065,377.75
2103	Байр ашиглалттай холбоотой холбоотой тогтмол зардал	12,592,800.00	44,436,000.00
210304	Байрны түрээс	12,592,800.00	44,436,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,564,700.00	16,150,197.59
210401	Бичиг хэргийн зардал	3,640,200.00	7,197,640.00
210403	Шуудан, холбоо, интернетийн зардал	3,100,000.00	4,331,557.59
210402	Тээвэр шатахуун	1,824,500.00	4,621,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,532,000.00	2,649,700.00
210702	Дотоод томилолтын зардал	998,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	534,000.00	2,649,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил,үйлчилгээний төлбөр хураамж	92,420,476.90	54,461,983.20
210806	Мэдээлэл, сурталчилгааны зардал	92,394,808.00	41,817,000.00
210802	Аудитын үйлчилгээний зардал	-	12,256,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	228,304.00
210808	Банк санхүүгийн байгууллагын шимтгэл	25,668.90	160,679.20
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	20,256,700.00	27,711,043.24
210902	Сургалт, семинарын зардал	20,256,700.00	-
210903	Элэгдлийн зардал	-	27,711,043.24
213	Урсгал шилжүүлэг	-	23,303,110.87
213306	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	23,303,110.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	338,982,031.01	1,890,280,611.19
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,229,087.81	44,292,196.31
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит бус)	14,229,087.81	44,292,196.31
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРЛАГЫН ДҮН	-	408,016,813.84
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит бус)	-	1,792,949.61
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэг	-	406,223,864.23
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	14,229,087.81	(363,724,617.53)
5	НИЙТ ҮР ДҮН	353,211,118.82	1,526,555,993.66

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	540,532,643.91	2,286,107,672.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	540,532,643.91	2,286,107,672.85
120	Нийтлэг татварын бус орлого	540,532,643.91	1,862,918,518.85
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	540,532,643.91	1,862,918,518.85
12000	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,485,743.91	23,303,110.87
	Бусад орлого	-	342,000.00
12000	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	6,987,292.00
12000	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	539,046,900.00	1,832,286,115.98
1220	Тусламжийн орлого	-	423,189,154.00
122002	Буцалтгүй Тусламжийн орлого		423,189,154.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	208,537,904.90	404,734,384.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,537,904.90	404,734,384.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,550,612.90	381,431,273.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	59,092,800.00	232,523,014.61
210101	Цалин	59,092,800.00	232,523,014.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,091,136.00	29,065,377.75
210201	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	7,091,136.00	29,065,377.75
2103	Байр ашиглалттай холбоотой холбоотой тогтмол зардал	12,592,800.00	44,436,000.00
210304	Байрны түрээс	12,592,800.00	44,436,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,564,700.00	16,150,197.59
210401	Бичиг хэргийн зардал	3,640,200.00	7,197,640.00
210403	Шуудан, холбоо, интернетийн зардал	1,824,500.00	4,331,557.59
210402	Тээвэр шатахуун	3,100,000.00	4,621,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,532,000.00	2,649,700.00
210702	Дотоод томилолтын зардал	998,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	534,000.00	2,649,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил,үйлчилгээний төлбөр хураамж	112,677,176.90	54,461,983.20
210806	Мэдээлэл, сурталчилгааны зардал	112,677,176.90	41,817,000.00
210802	Аудитын үйлчилгээний зардал	-	12,256,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	228,304.00
210808	Банк санхүүгийн байгууллагын шимтгэл	-	160,679.20
2108	Бусад зардал	-	2,145,000.00
210801	Санхүүгийн программын үлдэгдэл төлбөр		2,145,000.00
210903	Элэгдлийн зардал		
213	Урсгал шилжүүлэг	6,987,292.00	23,303,110.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,987,292.00	23,303,110.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)	331,994,739.01	1,881,373,288.83
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	68,833,066.00	453,183,156.63
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,833,066.00	453,183,156.63
222001	Туслах хэрэгсэл болон тоног, төхөөрөмжийн зардал	-	296,953,156.63
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	68,833,066.00	156,230,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(68,833,066.00)	(453,183,156.63)
14	Бусад эх үүсвэр	-	
145001	Валютын ханшны зөрүү	14,229,087.81	42,499,246.70
7	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VII)	14,229,087.81	42,499,246.70
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(III)+(VI)+(VII)	277,390,760.82	1,470,689,378.90
3111-3122	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	277,390,760.82
3111-3122	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	277,390,760.82	1,748,080,139.72

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	ЗГ хувь оролцооны нийт дүн	Нийт дүн
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Тайлант үеийн үр дүн	353,211,118.82	-	353,211,118.82
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	353,211,118.82	-	353,211,118.82
Тайлант үеийн үр дүн	1,526,555,993.66		1,526,555,993.66
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,879,767,112.48	-	1,879,767,112.48

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,005,886,100.00	834,614,429.78	(1,171,271,670.22)	41.6%
УРСГАЛ ЗАРДАЛ	921,969,600.00	384,931,273.15	(537,038,326.85)	41.8%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	921,969,600.00	384,931,273.15	(537,038,326.85)	41.8%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	921,969,600.00	384,931,273.15	(537,038,326.85)	41.8%
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,083,916,500.00	449,683,156.63	(634,233,343.37)	41.5%
Барилга байгууламж	407,916,500.00	-	(407,916,500.00)	0.0%
Тоног төхөөрөмж	676,000,000.00	449,683,156.63	(226,316,843.37)	66.5%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,005,886,100.00	2,255,475,269.98	249,589,169.98	112.4%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,561,969,600.00	1,832,286,115.98	270,316,515.98	117.3%
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,561,969,600.00	1,832,286,115.98	270,316,515.98	117.3%
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	443,916,500.00	423,189,154.00	(20,727,346.00)	95.3%
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	443,916,500.00	423,189,154.00	(20,727,346.00)	95.3%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	277,390,760.82		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,698,251,601.02		

ТЭМДЭГЛЭЛ

Lined area for writing, consisting of multiple horizontal dotted lines.

